



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРЭЭС

2009 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Иргэний нисэхийн үйл ажиллагааны талаар асуулга /SAAQ/-ын хариулт

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Нисэхийн аюулгүй ажиллагаа, хяналт зохицуулалтын алба /П.Мөнхжаргал/-д дараах үүргийг өгөв. Үүнд:

- Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас ирж байгаа баримт бичгүүдийг бүртгэх, тараах, хэрэгжилтийг зохицуулах журам"-ыг ИНЕГ-ын хамтын ажиллагааны хэлтэстэй хамтран боловсруулж, батлуулах;
- Техникийн албан хаагчдыг бэлтгэх, хөгжүүлэх бодлого боловсруулж, даргын зөвлөлийн хуралд танилцуулах;
- Аюулгүй байдлын бодлогын баримт бичиг боловсруулж, батлуулах;
- Иргэний агаарын тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны аюулгүй байдалд үзүүлж болохуйц эрсдлээс урьдчилан сэргийлэх, хянах, таньж мэдэх үйл ажиллагааг тогтоох журам боловсруулж, батлуулах;
- Нислэгийн ур чадварын шалгалтын гарын авлага, суралцагчийн гарын авлагыг тус тус боловсруулах ;
- Үнэмлэхжүүлэлт, мэргэжлийн ур чадварын шалгалт авах журам боловсруулан, батлуулах;
- Code share эрх зүйн үндэслэлийг судлан, холбогдох заалтыг дүрэм журамд оруулах;
- Хөрш орнуудтай цаг уурын үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулах ажлыг Аэронавигацийн мэргэжлийн хэлтэстэй хамтран зохион байгуулах

2. Захиргаа, хүний нөөцийн ерөнхий менежер Т.Батжаргалд дараах үүргийг өгөв.

Үүнд:

- Иргэний нисэхийн салбарын сургалтын хөтөлбөрийг боловсруулж энэ оны 11 дүгээр сарын 01-ний дотор даргын зөвлөлийн хуралд оруулах; Сургалтын хөтөлбөрт сургалтад хамрагдсан ажилтанг шалгаж байх тухай заалт оруулах;
- Номын сан байгуулах төлөвлөгөө, түүнийг байгуулахад шаардагдах төсөв гаргаж батлуулах, байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

3. Эдийн засгийн зохицуулалт, хамтын ажиллагааны ерөнхий менежер С.Итгэлд дараах үүргийг өгөв. Үүнд:

- "Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас ирж байгаа баримт бичгүүдийг бүртгэх, тараах, хэрэгжилтийг зохицуулах журам"-ыг НААХЗА-тай хамтран боловсруулж, батлуулах;

- Гадаадад албан томилолтоор ажиллах журам-д гадаадад сургалтад хамрагдсаны талаар тайланг хамгаалдаг системд оруулах талаар тусгаж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

4. Аэронавигацийн мэргэжлийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч С.Буяндалайд дараах үүргийг өгөв. Үүнд:

- ИКАО-гийн PANS-OPS /Doc 8168/-ын шаардлагыг тусгасан “Хэрэглэлийн нислэгийн журам” боловсруулан, батлуулах;
- Хэрэглэлийн нислэгийн журам зохиогч / procedure designers/-ийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан, батлуулах;
- Хөрш орнуудтай цаг уурын үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулах ажлыг НААХЗА-ны Аэродром, аэронавигацийн хэлтэстэй хамтран зохион байгуулах ;
- “Таних тэмдэг, радио дуудлага 24-bit aircraft addresses” харилцааг зохицуулах журам боловсруулан, батлуулах
- CNS тоног төхөөрөмжийг гэрчилгээжүүлэх, ажилд оруулах эрх олгох журам-ыг сайжруулах;
- Иргэний нисэхийн шалгалтын нислэгийн ерөнхий шаардлагыг боловсруулах, шалгалтын нислэгийг гүйцэтгэх зааврыг боловсруулах;
- Нисэхийн радио давтамжийн менежмент, радио давтамжийн спектрыг хамгаалах, радио давтамжийг хөндлөнгийн нөлөөлөлд ажиллах процедур, зохицуулалтыг уг асуудлыг хариуцсан АНМХ-ийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод оруулж, хариуцуулж ажиллуулах;
- SAAQ-ийн 5.6.10-т туссан асуудлаар Батхаантай хамтран төлөвлөгөө гаргах;


5. Нисэх буудлын үйлчилгээний мэргэжлийн хэлтсийн дарга Ч.Сэрд-Янживт дараах үүргийг өгөв. Үүнд:

- Аэродромын зааврыг байгууллагын Вэбсайтад тавих;
- Аэронавигацийг хөгжүүлэх төлөвлөгөөний дагуу аэродромыг тоног төхөөрөмжөөр хангах хөтөлбөр боловсруулан, батлуулах;
- Одоо ажиллаж байгаа бүх аэродромуудад гал унтраах үйлчилгээ үзүүлж байгаа байдлын судалгаа хийж, цаашид энэ үйлчилгээг сайжруулах төлөвлөгөө гаргах;

6. ИКАО-гийн ээлжит аудит шалгалтад бэлтгэх ажлын хэсэг /Д.Батчулуун/-т дараах үүргийг өгөв. Үүнд:

- 2.3, 2.5-д тайлбар бичих;
- 2.11- дэлгэрүүлж бичих;
- 2.12-ыг ойлгомжтой болго. Үг хэллэгийг засах. Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиас холбогдох заалтуудыг оруулах;
- 2.15-ыг тийм гэсэн хариулт болго. Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиас холбогдох заалтуудыг оруулах;
- 2.16-д ИНД-173-ийг нэмэх, CAR байхгүй байна. Нэмж оруулан сайжруулах.
- 2.26-д эрх шилжүүлсэн гэрээг нэмж оруулах, Буяндалайгаас холбогдох мэдээллийг авах. Эрэн хайх авран туслах хэлэлцээрийг оруулах;
- 3.1.9-д 30 хүн гэсэн байна. Үүнийг Authority, Administration ялгааг гаргасны дараа хариулах;

- 3.1.10-д Нисэх буудлын үйлчилгээний мэргэжлийн хэлтсийн хүний тоог бичих
- Annex 4, 5 хариуцах эзнийг тодруулж, тушаал гарга;
- Annex 6-ийн шаардлагыг дүрэмд оруулах ажлыг тус ажлын хэсгийн гишүүн Ө.Батсайхан хариуцан гүйцэтгэх;
- ИНД-119 б бүлэгийг сайжруулах ажлыг тус ажлын хэсгийн гишүүн Ө.Батсайхан хариуцан гүйцэтгэх;
- 4.4.45-д Mandatory reporting system-тэй болоход цаашид анхаарах;
- /CNS/ “Тоног төхөөрөмжийг гэрчилгээжүүлэх, ажилд оруулах эрх олгох журам”-ыг сайжруулах ажлыг ажлын хэсгийн гишүүн Гантөгс АНМХ-тэй хамтран гүйцэтгэх ;
- Иргэний нисэхийн шалгалтын нислэгийн ерөнхий шаардлагыг ажлын хэсгийн гишүүн Гантөгс АНМХ-тэй хамтран боловсруулах;
- 3.1.21-д 5 заалтаар тусад нь тодорхой бичих. ИКАО-гийн ажилтнаас тодруулах;



ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.СУВДАА